



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 405

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Ланд круйзер 200 маркын 0060 БРА улсын дугаартай, 2017 онд үйлдвэрлэсэн, 159,000,000.00 (Нэг зуун тавин есөн сая) төгрөгийн балансын үнэтэй, 23,849,999.91 (хорин гурван сая найман зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн нэгэн мөнгө) хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Мэндсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



000022

"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашиныг
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлэх хөрөнгө

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн
...:05 дугаар тогтоолын хавсралт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/а шиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/		Үлдэгдэл өртөг
				Балансын үнэ	Хурин гурван сая найман зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн нэгэн мөнгө)	
1	Ланд круйзер 200, 00-60 БРА, суудлын, арал: JTMH017J4160658	2017/2018	63653	159,000,000.00	23,849,999.91	135,150,000.09
Нийт дүн				159,000,000.00 (Нэг зуун тавин есөн сая)	23,849,999.91 (Хорин гурван сая найман зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн нэгэн мөнгө)	135,150,000.09 (Нэг зуун гучин таван сая нэг зуун тавин мянга)